



## ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Өрсөлдөөний тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

### 1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Их хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 22-т "Өрсөлдөөний тухай хуулийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж байгаа бэрхшээлийг шийдвэрлэх, уг хуулийг зах зээлийн эдийн засгийн харилцааг зохицуулах суурь хууль болгон өөрчлөн шинэчлэх" гэж, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.13-т "Зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулна" гэж тус тус заасан байна.

### 1.2.Практик шаардлага:

Зах зээлийг чөлөөт, шударга өрсөлдөөний зарчмаар хөгжүүлэх зорилгоор дэлхийн бусад улс орнуудын хөгжлийн нийтлэг жишигт нийцүүлэн 1993 онд Монгол Улсын Их Хурлаас Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг батлан гаргажээ. Улс орны гадаад, дотоод орчин нөхцөл, нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй холбоотойгоор уг хуулийг 2010 онд Өрсөлдөөний тухай хууль нэртэйгээр шинэчлэн баталсан нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна.

Улс орны эдийн засаг эрчимтэй хөгжиж, олон улсын чиг хандлага болон зах зээлийн харилцаа гүнзгийрч байгаатай холбоотойгоор одоогийн мөрдөгдөж байгаа Өрсөлдөөний тухай хуулийг шинэчлэн найруулах дараах практик шаардлага тулгарч байна. Үүнд:

1.Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Өрсөлдөөний тухай хуулиар зах зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг урьдчилсан байдлаар тогтооор зохицуулсан байгаа нь учир дутагдалтай бөгөөд зах зээлд оролцогчдын нөхцөл байдал байнга өөрчлөгддөгтэй холбоотойгоор энэ зохицуулалт нь бодит нөхцөл байдалд төдий л нийцэхгүй, зорилгодоо хүрч чадахгүй байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 78 мянга гаруй аж ахуйн нэгжийг үйл ажиллагаа явуулж байгаа зах зээл тус бүрээр нь судлан давамгай байдалтай эсэхийг тогтоож, уг аж ахуй эрхлэгч бүрийн зах зээлийн эзлэх хувь өөрчлөгдөхийг мөн тухай бүр судлан тогтоох шаардлагатай болдог. Энэ нь хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө мөнгө ихээхэн шаарддагаас бодит байдалд хэрэгжүүлэх боломжгүй болоод байна.

Өрсөлдөөнийг бодитоор хязгаарлаж хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан эсэхийг тогтоох явцдаа давамгай байдалтай байгаа эсэхийг тогтоох учир үүнийг ийнхүү өмнө нь урьдчилан тогтоож байгаа нь ач холбогдолгүй бөгөөд шаардлагагүй юм. Иймд зөрчлийг хянан шалгах явцад уг зөрчил үйлдэгдэх үед тухайн холбогдогч аж ахуй эрхлэгч холбогдох зах зээлд давамгай байдалтай байсан эсэхийг тогтоож байхаар хуулийн зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай байна.

2.Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Өрсөлдөөний тухай хуулиар зөвхөн давамгай байдалтай хуулийн этгээд бусад этгээдтэй нэгдэн, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, эсхүл ижил төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулдаг өрсөлдөгч компанийн энгийн хувьцааны 20-оос дээш, давуу эрхийн хувьцааны 15-аас дээш хувийг худалдан авах, эсхүл харилцан хамаарал бүхий этгээдтэй нэгдэх, нийлэх тохиолдолд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас нэгдэн, нийлэлт нь зах зээлд сүргөөр нөлөөлөх эсэх талаар дүгнэлт гаргуулахаар хандах зохицуулалттай. Гэтэл практикт давамгай байдалтай бус хэд хэдэн аж ахуй эрхлэгчид нэгдэх, нийлэх үйл ажиллагаа явуулахад ямар нэг хяналт байхгүй бөгөөд энэ тохиолдолд зах зээл дээр хэт төвлөрөл бий болгох улмаар өрсөлдөөнийг хязгаарлах боломжтой байна. Дээр дурдсан тохиолдол бодитоор гарч байгаа нь тодорхой салбарын өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг үүсгэж байна.

Иймд хуулийн этгээд нь давамгай байдалтай эсэхээсээ үл хамааран тодорхой шалгуурыг хангасан хуулийн этгээд нэгдэн, нийлэх, өрсөлдөгчийн тодорхой хувийг худалдан авахдаа Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагад хандан өрсөлдөөнд сүргөөр нөлөөлөх эсэх талаарх дүгнэлт гаргуулдаг байх зохицуулалт шаардлагатай байна.

3.Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбоотой хууль хоорондын уялдааг хангах зайлшгүй шаардлага тулгарч байна. Тухайлбал: Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлд төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагаас өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулахыг хориглосон зохицуулалт байдаг. Гэтэл Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд “захиргааны байгууллага”-ыг тодорхойлсон нь Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаас илүү өргөн хүрээтэй байна. Өөрөөр хэлбэл Өрсөлдөөний тухай хууль нь “захиргааны байгууллага”-ыг Захиргааны ерөнхий хуульд зааснаас зөрүүтэйгээр тодорхойлсон тул өрсөлдөөнд нөлөөлөхүйц шийдвэр гаргах боломжтой “захиргааны бхийгууллага”-ыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн томьёолох шаардлагатай.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж болох нийтлэг хөөн хэлэлцэх хугацаа нь өрсөлдөөний зохицуулалтын харилцаанд тохирохгүй байна. Учир нь өрсөлдөөний зөрчил нь нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг үр дагавраараа бусад захиргааны зөрчилтэй харьцуулахад үлэмж их бөгөөд зарим зөрчил нь нууц, далд байдлаар явагддагаас илрүүлж тогтооход хүндрэлтэй, тооцоо судалгаа харьцангуй их хийгддэг зэргээс хугацаа их зарцуулдаг. Олон улсад өрсөлдөөний зөрчилд хэрэг үүсгэж шалгах, хариуцлага хүлээлгэх хөөн хэлэлцэх хугацааг 3-5 жил байхаар тогтоосон жишиг байдаг<sup>1</sup>.

Зөрчлийн тухай хуульд хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо тухайн зөрчилд хүлээлгэх шийтгэлийн хэмжээтэй уялдуулан заасан байна. Мөн хуулийн 1.5 дугаар

<sup>1</sup> Япон улсад хөөн хэлэлцэх хугацааг 5 жилээр, БНСУ улсад хөөн хэлэлцэх хугацааг 3 жилээр тогтоосон байдаг.

зүйлийн 1.3, З дахь хэсгүүдэд тус тус зааснаар хамгийн ихдээ 200.000 нэгж буюу 200.000.000 төгрөгөөр торгох шийтгэлд хөөн хэлэлцэх хугацаа 2 жил байхаар заасан байна. Гэтэл Өрсөлдөөний тухай хууль зөрчсөн ихэнх зөрчилд тухайн зөрчил гаргасан этгээдийн өмнөх жилийн борлуулалтын орлогоос хувь тооцож торгохоор заасан байдгаас Зөрчлийн тухай хуульд заасан 200.000 нэгжээс давсан хэмжээний тorgуулийг хуулийн этгээдэд оногдуулдаг. Иймд Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “Зөрчлийг хөөн хэлэлцэх хугацааг өөр хуулиар тогтоосон бол тухайн хуулийг дагаж мөрднө.” гэж заасанд нийцүүлэн Өрсөлдөөний тухай хууль зөрчсөн үйлдэлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах хөөн хэлэлцэх хугацааг тусгайлан тогтоож өгөх нь зүйтэй байна.

4. Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд хийсэн хяналт, шалгалтын үр дүнгийн талаарх шийдвэр болох зөрчлийн талаарх эцсийн шийдвэрийг улсын байцаагч буюу нэг этгээд дангаараа гаргаж, улсын байцаагчийн гаргасан уг шийдвэрийг зөрчилд холбогдогч этгээд эс зөвшөөрвөл шууд шүүхэд маргаан үүсгэж байгаа өнөөгийн зохицуулалт нь учир дутагдалтай болох нь практикаар нотлогдож байна. Учир нь Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн талаарх шийдвэр нь тухайн аж ахуй эрхлэгчийн бизнесийн нэр хүнд, ашиг орлогод шийдвэрлэх нөлөө үзүүлэхээс гадна, хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх тorgуулийн хэмжээ өндөр бөгөөд зарим тохиолдолд хэдэн тэрбум төгрөгөөр хэмжигддэг тул зөрчилд холбогдогч этгээд улсын байцаагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй маргаан үүсгэж, шүүхийн ачааллыг нэмэгдүүлэх явдал түгээмэл байна.

Иймд Өрсөлдөөний тухай хууль зөрчсөн талаар гаргасан улсын байцаагчийн шийдвэрийг тухайн зөрчилд холбогдогч болон гуравдагч этгээд эс зөвшөөрвөл гомдоо шүүхийн өмнөх шатанд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороонд гаргаж шийдвэрлүүлдэг байх, уг хорооноос гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд хандах зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Энэ нь Өрсөлдөөний тухай хууль зөрчсөн эсэх талаарх зөрчил шалган шийдвэрлэх явцад үүсч болзошгүй нөлөөллийг бууруулах, шийдвэр оновчтой байхад зерэг нөлөөтэй юм.

5. Хууль хэрэглээний явцад Өрсөлдөөний хуулийн зарим зохицуулалтууд тодорхой бус байгаагаас шалтгаалан шүүхийн шатанд хэргийг хянан шийдвэрлэхэд нэг төрлийн хэрэг, маргааныг харилцан адилгүй шийдвэрлэж байна. Тухайлбал, Өрсөлдөөний тухай хуулийн 12.1-д “Аж ахуй эрхлэгч өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан заалтуудыг зөрчсөн тохиолдолд өрсөлдөөнд шууд харшлах үр дагавар үүсгэнэ гэж үзэж улсын байцаагчийн шийдвэрийг хуулийн хүрээнд гарсан гэж шийдвэрлэсэн шүүхийн практик байхад тухайн заалтыг зөрчсөнөөс гадна бусдын өрсөлдөөнд харшаар нөлөөлсөн үр дагаврыг нотлохыг нэмж шаардах байдлаар улсын байцаагчийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн тохиолдол мөн байдаг. Иймд өрсөлдөөний хуулиар хориглосон, анхнаасаа шууд өрсөлдөөнд харш үр дагавар үзүүлэхээр заасан, өөрөө хэлбэл үр дагавар гаргасан байхыг шаардалгүйгээр хуулиар хориглодог зарим үйлдлүүдийг илүү тодорхой, ойлгомжтой байдлаар томъёолох нь хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх хэрэглээ бий болгох ач холбогдолтой юм.

6. Өнөөдрийн байдлаар Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах байгууллага нь хамтын удирдлагын зарчмаар ажиллахаар Өрсөлдөөний тухай хуулинд тусгагдсан боловч байгууллагын оноосон нэрийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гэж зааж өгсөн байдаг. Олон улсын жишигт өрсөлдөөний асуудал хариуцсан байгууллагууд нь хамтын удирдлагын зарчмаар ажиллаж, хороо

гэсэн нэртэй байдаг<sup>2</sup> төдийгүй Монгол Улсад ч хамтын удирдлагын зарчмаар ажилладаг байгууллагууд нь хороо, комисс гэж нэрлэх нийтлэг жишиг байдаг<sup>3</sup>.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гэх нэр нь бусдад хамтын удирдлагын зарчмаар ажилладаг гэх ойлголтыг шууд илэрхийлж чаддаггүй бөгөөд цаашлаад уг байгууллагын орон тооны болоод орон тооны бус гишүүд чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахад олон нийтэд төдийгүй төрийн байгууллагын түвшинд ч үл ойлгогдох байдал байнга үүсдэг. Тиймээс өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагын оноосон нэрийг "хороо" гэж өөрчлөх нь олон улсын жишиг нийцэх бөгөөд практикт тулгарах хүндрэлийг шийдвэрлэх юм. Түүнчлэн Өрсөлдөөний тухай хуульд ззаснаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар өрсөлдөөний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулахаар тусгасан байдал. Гэвч энэ байгууллага өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод 36 алба хаагчийн орон тоотой<sup>4</sup>, орон нутагт ямар ч салбар нэгжгүй ажиллаж байна.

Анх 2004 онд Засгийн газрын 222 дугаар тогтоолоор Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрыг байгуулахдаа 33 алба хаагчийн орон тоотой ажиллуулахаар байгуулж байсан бөгөөд тухайн үед энэ байгууллага нь зөвхөн Өрсөлдөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэгтэй байсан бол 2008 онд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, 2010 онд Зар сурталчилгааны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг уг байгууллагад нэмж хүлээлгэсэн боловч орон тоо, төсвийг огт нэмээгүй байна.

Энэ нь Өрсөлдөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, өрсөлдөөний талаар төрөөс баримтлах бодлого боловсруулж улс орон даяар хэрэгжүүлэх ажилд хүн хүч дутагдаж, хуулийн хэрэгжилт сул байх нөхцлийг бүрдүүлж байна. Иймээс өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагын бүтцийг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжтой байхаар боловсронгуй болгох шаардлагатай талаар олон зөвлөмжийг өгсөн байdag.

8. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Худалдаа Хөгжлийн Бага хурлаас олон улсын түвшинд шударга бус өрсөлдөөнийг хориглох нөхцлийг бүрдүүлэх, бодлого зохицуулалт, түүний хэрэгжилтэд заавар зөвлөмж, дүн шинжилгээ хийх зэрэг үйл ажиллагаа явуулах хүрээнд Монгол Улсын Өрсөлдөөний хууль ба бодлогод 2012 онд дүн шинжилгээ хийж судалгааны тайлан гаргасан<sup>5</sup> байна. Уг тайланд Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, өөрчлөлт оруулах шаардлагатай талаар олон зөвлөмжийг өгсөн байdag.

#### **Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т заасныг үндэслэн хуулийн нэр томьёог оновчтой болгох, зарим зүйл, заалттыг хүчингүй болгох, шинээр зүйл, заалт нэмэх зэргээр хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт

<sup>2</sup> Японы Шударга худалдааны хороо, Солонгосын Шударга худалдааны хороо, АНУ-ын Холбооны худалдааны хороо, Австралийн Өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо гэх мэт

<sup>3</sup> Санхүүгийн зохицуулах хороо, Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, Эрчим хүчний зохицуулах хороо, Хүний эрхийн үндэсний комисс гэх мэт

<sup>4</sup> Үүнээс Монгол Улсын Шадар сайдын "Бүтэц батлах тухай" 2016 оны 103 тоот тушаал, агентлагийн даргын "Албан тушаалын жагсаалт батлах тухай" А/125 тоот тушаалаар 8 алба хаагч л Өрсөлдөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулан ажиллаж байна.

<sup>5</sup> НҮБ-ийн Худалдаа хөгжлийн бага хурал, Өрсөлдөөний хууль ба бодлогод хийсэн сайн дурын дүн шинжилгээ. Монгол Улс, Дэлгэрэнгүй тайлан, 2012 он

оруулах шаардлагатай байгаа тул төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна. Хуулийн төсөл нь 5 бүлэгтэй байх бөгөөд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараахь байдлаар тусгана. Үүнд:

Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хамрах хүрээ, хуулийн нэр томъёог олон улсын жишигт болон Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн хуулийг нэг мэр, ойлгомжтой байхаар тусгана. Хоёрдугаар бүлэгт өрсөлдөөнийг хэрхэн зохицуулах, аж ахуй эрхлэгчийн ямар үйлдлийг хориглох, захиргааны байгууллагаас зах зээл, өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөхүйц ямар үйл ажиллагаа явуулахыг хориглох зэрэг зохицуулалт, Гуравдугаар бүлэгт өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн байгууллагын эрх зүйн байдлыг хамтын удирдлагын зарчмаар үйл ажиллагаа явуулдаг байхаар зохицуулна. Дөрөвдүгээр бүлэгт өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчсөн зөрчил хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой онцлог зохицуулалтыг тусгана. Тавдугаар бүлэгт аж ахуй эрхлэгч, байгууллага, албан тушаалтны эрх үүрэг, өрсөлдөөний зөрчлийг хөөн хэлэлцэх хугацаа зэрэг зохицуулалтыг тусгахаар хуулийн төслийг боловсруулна.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар дараахь зэрэг үр дүн гарна гэж үзэж байна.

Өрсөлдөөний эрх зүйн орчин олон улсын жишигт нийцүүлснээр Монгол Улс дахь бизнесийн орчин сайжрах боломж бурдэж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэх, эдийн засгийн салбарууд хурдацтай хөгжихдээ зэрэг нөлөө үзүүлнэ.

Түүнчлэн хуулийн этгээд бусад хуулийн этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад компанийн тодорхой хувийг худалдан авахад Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хорооноос холбогдох дүгнэлт авснаар зах зээлийн төвлөрөл үүсэх, улмаар аж ахуй эрхлэгчид өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх боломж бурдэнэ.

Хуулийн материаллаг эрх зүйн зохицуулалт буюу монополийн зохицуулалт, өрсөлдөөнд харш хэлцэл, шударга бус худалдааны үйл ажиллагаа, захиргааны байгууллагын өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаа зэргийг цаг үеийн хөгжил, дэвшилд тулгуурлан, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, олон улсын онол, практикт хэрэглэж заншсан сайн туршлагатай уялдуулан нарийвчлан, оновчтой тодорхойлсон эрх зүйн орчин бурдэнэ. Ингэснээр Өрсөлдөөний тухай хууль тогтоомж нь зах зээлийн харилцаанд оролцогчдын үндсэн дүрэм, журам нь болж бизнесийн ёс зүйтэй харилцааг бий болгоход хувь нэмэр оруулна.

Аж ахуй эрхлэгчид зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөл бурдэж, тэдний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд ач холбогдолтой бөгөөд улмаар дэлхийн зах зээлд Монгол Улсын өрсөлдөх чадвар нэмэгдэн улс орны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд түлхэц болно. Түүнчлэн өрсөлдөөний асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүрэг, эрхлэх асуудал, бүрэн эрх зохистой түвшинд хүрч, чиг үүргээ хараат бус байдлаар бие даан хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэнээр хуулийн хэрэгжилт сайжирна. Өрсөлдөөний асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа, шийдвэр гаргах явц нарийвчлан зохицуулагдснаар уг байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд холбогдуулан гарах шийдвэр хууль ёсны буюу үндэслэл бүхий байх шаардлага хангагдана. Тодруулбал Өрсөлдөөний хуулийг зөрчсөн эсэх талаар улсын байцаагч дангаараа гаргасан шийдвэрийг хамтын удирдлагын зарчим бүхий Хороо шүүхийн өмнөх шатанд гомдлын дагуу хянадаг тогтолцоо бий болно.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн тухай**

Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцэх бөгөөд уг хуулийн төсөлтэй уялдуулан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус зэрэгцүүлэн боловсруулна.

---000---